

## **ГАРЧИГ**

УДИРТГАЛ.....	2
НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	8
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН.....	13
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	63
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	68
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	77
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	77
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	79
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	94
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	113
АРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	125
АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	128
АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	133
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА /2022 ОН/.....	138
ДҮГНЭЛТ.....	139

## **УДИРТГАЛ**

“Болд төмөр Ерөө гол” ХХК нь (“БТЕГ”ХХК) Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Төмрийн хүдрийг ил аргаар олборлох төсөл хэрэгжүүлж байна. Тус компани Монгол Улсын

холбогдох хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-г төслийн бүхий л үе шатанд мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэж, түүний зөвлөмж, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Болд төмөр Ерөө гол” ХХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагын тэнцвэрийг олох зарчмаар тогтвортой хөгжлийг дэмжих үүрэг хүлээсэн билээ. Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд дараах үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Үүнд:

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх;

- Ашигт малтмалын хайгуул хийх, барилга байгууламж барих, уурхайн олборлолт ба уурхайн хаалт зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх;

- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

- Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах;

- Компанийн ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, эргэх холбоо бүхий ажил хэрэгч харилцааг буй болгох;

- Нутгийн ард иргэдийн уламжлал, соёлыг хүндэтгэж хамгаалах; “БТЕГ” ХХК-ний 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын баталсан журмын дагуу боловсруулав.

## НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Баянголын төмрийн хүдрийн ордын MV-008888, MV-017607 ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Болд төмөр Ерөө гол” ХХК нь эзэмшдэг.

Баянголын ордыг ашиглалтанд оруулж, төмрийн баяжмал, бөөмцөг (агломераци) үйлдвэрлэх үйлдвэрийг уг ордыг түшиглэн байгуулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь Монгол улс дахь металлургийн үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, бүс нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зэрэг олон эерэг талтай хэмжээн үзэж “Болд төмөр ерөө гол” ХХК-ийн зүгээс уг ордыг ашиглахаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан болно.

Баянгол төмрийн орд газрыг ашиглах MV-008888 тусгай зөвшөөрлийг 2004 оны 12-р сард 60-н жилийн хугацаатай авч, орд газрыг ашиглах техник-эдийн засгийн үндэлэлийг 2019 онд шинэчлэн батлуулж, 2020 онд орд газрыг ашиглахад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотголыг хийлгүүлж ажилласан. Хүснэгт-1-г 2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хөрс хуулалт, хүдэр олборлолт, уулын цулын хэмжээ болон тайлант оны гүйцэтгэлийг 10 сарын 20-ны байдлаар үзүүлсэн байна.

### *Хүснэгт-1. Уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэл.*

№	Үзүүлэлт	Хэм.нэгж	Оны эхнээс		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь %
1	Уулын цул	мян.м3	13 669.220	10 897.247	80%
2	Хөрс хуулалт	мян.м3	12 580.083	9 845.912	78%
3	Хүдэр олборлолт	мян.тн	4 512.465	4 493.471	99%

**Ажиллах хүчний тухай мэдээлэл:** Компани нь анх байгуулагдсанаас хойш ажлын байрыг байнга нэмэгдүүлж ирсэн ба цаашид ч нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байна. Баянголын уурхайд Улаанбаатар хот болон 21 аймгуудын харъяалалтай 1600 орчим ажилтан ажиллаж байна.

**Төслийн товч танилцуулга:** MV-008888 ашиглалтын талбайд 2004-2007, MV-017607 ашиглалтын талбайд 2018 онуудад хайгуулын ажил хийгдэж нийт **хүдэр В** нөөц 89.66сая.тн, **С** нөөц 61.51сая.тн, **В+С** нөөц 151,17 сая.тн, **металл В** нөөц 41.48 сая.тн, **С** нөөц 24.64 сая.тн, **В+С** нөөц 66.12 сая.тн тус тус батлагдсан. Олборлолтын ажил 2008 хойш хийгдэж эхэлсэн. 2019 онд батлагдсан ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголоор жилийн хүчин чадал 5000 мян.тн хүдэр олборлох ба энэ хүчин чадлаар 12 жил ашиглахаар тусгагдсан байна. Үйл ажиллагаа эхэлсэнээс хойш /2021.10.20-ны байдлаар/ уурхайн карьерын нөлөөнд 152.8 га, хөрсний овоолгын нөлөөнд 254.1 га талбай өртөгдсөн байна. Тайлант онд 2.4га талбайд карьерын тэлэлт, 20.9га талбайд овоолгын тэлэлт явагдсан байна. 2008-2021 оны хооронд биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын чиглэлээр 136.1га талбайд ойжуулалт, биологийн нөхөн сэргээлтийн ажил, 2010-2021 онуудад техникийн

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**


нөхөн сэргээлтийг 51.1га-д хийж гүйцэтгэсэн. Үүнээс 2021 онд Зүүн уурхайн хөрсний 1-р овоолгын 7 га-д техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын чиглэлээр Бугант тосгоны Толгойтын аманд (хуучин нинжа нарын ухсан эзэн холбогдогчгүй газар) 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 1.2 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийж ажиллалаа.

Цаашид биологи, техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын ажлыг ТЭЗҮ, хаалтын нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн дагуу үргэлжлүүлэн шат дараатай хийж гүйцэтгэж ажиллана.

**Төсөл хэрэгжилтийн явц:** Батлагдсан нөөцийн дагуу Баруун, Зүүн гэсэн 2 ил уурхай, хуурай хүдэр баяжуулах 5-н үйлдвэр ажиллаж байна. Баянголын төмрийн хүдэр олборлох ил уурхай нь олон төрлийн холимог шинж чанартай бөгөөд одоогийн байдлаар өндөр агуулгатай төмрийн хүдрийг гарган авахын тулд одоогоор хуурай соронзон сеператорыг ашиглаж байна. Шинээр барих соронзон-флотаци хосолсон аргаар баяжуулах үйлдвэрийн байршлыг зүүн биетийн шулуун шугамаас 4.3км зайд, баруун биетийн шулуун шугамаас 6.3км зайд, төмөр замын ачиж буулгах талбайгаас 1.6км зайд баяжуулах үйлдвэрийн эдэлбэр газрын зөвшөөрөлтэй 50.0 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Төмрийн хүдрийг ангилан ялгах хэсэг нь дараах дамжлагуудаас бүрдэнэ.

- Хүдрийг буталж, боловсруулалтанд бэлдэх
- Соронзон аргаар ялган, ангилах
- Хаягдлыг хадгалах зэрэг болно.

**Схем-1. Үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагааны технологийн дараалал.**



**Ил уурхайн ажиллах горим:** Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан 3-р сарын 15-аас 12-р сарын 15-ны хооронд, хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төсөлд тусгасан. Уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар үзүүлбэл:

- Жилийн нийт хоног 365 хоног
- Үндэсний баяр, ёслолын хоног 9 хоног
- Өвлийн улирлын сул зогсолт 90 хоног
- Засвар үйлчилгээ, бэлтгэл ажил 18 хоног
- Цаг агаарын нөхцөлийг тооцсон хоног 8 хоног
- Уурхайн жилд ажиллах хоног 240 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 2 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг тус тус байна.

**Ашиглагдаж буй техник технолги:**

**Уулын үндсэн техник тоног төхөөрөмжүүд.**

Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд дэлхийд ил уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр тэргүүлэх фирмүүдийн техник тоног төхөөрөмжүүдийг сонгон авч байна.

“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

Үүнд:

*Хүснэгт 2. Баянгол уурхайн хэмжээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт.*


№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Хүчин чадал	Тоо ширхэг	Үйлдвэрлэгдсэн улс
1	Экскаватор-CAT	3895CL	5.2м3	3	АНУ
2	Экскаватор-KOMATSU	PC 400	2.2м3	1	Япон
3	Экскаватор-KOBELCO	SK 330-7	1	Солонгос	
4	Экскаватор-HYUNDAI	LC-500	3.2м3	1	Солонгос
5	Экскаватор-VOLVO	EC700CL	4м3	6	БНХАУ
6	Цахилгаан экскаватор-TZ	WK-12	12м3	2	БНХАУ
7	Цахилгаан экскаватор-KOMATSU	PC -3000	12м3	1	Япон
8	Бульдозер-SHANTUI	SDR-22	6м3	5	БНХАУ
9	Ачигч-LIUGONG	ZL-50C	2.5м3	1	БНХАУ
10	Ачигч- VOLVO	L350	6.2м3	7	БНХАУ
11	Өрмийн машин-ATLAS COPCO	ROC-460PC	98мм	2	БНХАУ
12	Өрмийн машин-ATLAS COPCO	ROC-L-830	200мм	2	БНХАУ
13	Өрмийн машин-ATLAS COPCO	CDM-30	178мм	2	БНХАУ
14	Өрмийн машин-ATLAS COPCO	KQG-150V	110мм	2	БНХАУ
15	Автосамосвал-TEREX	TRX-50	50тн	16	БНХАУ
16	Автосамосвал-TEREX	TRX-100	100тн	9	БНХАУ
17	Автосамосвал-KOMATSU	HD-785-792	100тн	8	Япон
<b>Нийт</b>	<b>69</b>				
18	Баяжуулах үйлдвэр /хуурай/	4,0-6,0 сая	5		

**Баяжуулалтын технологи.**

**Баяжуулах үйлдвэрийн технологийн горим:** Агуулахаас ирэх 0-12мм-ийн ширхэглэлтэй 48%-ийн агуулгатай хүдэр нь MQY1836 маркийн бөмбөлөгт тээрэмд - 0.074мм-ийн ширхэглэлийн хэмжээ 40% хүртэл нунтаглагдан FX-660 маркийн ангилагч гидроциклонд ангилагдана. Ангилагчийн халиа СТВ-1245 маркийн анхан шатны болон 1-р цэвэрлэгээний соронзон сепараторуудаар баяжигдаж D3-CTS2425 маркийн цахилгаан соронзон шигшүүрт ялгагдана. Шигшүүрээс гарах төмрийн баяжмал СТВ-1030 маркийн 2-р цэвэрлэгээний соронзон сепаратороор баяжигдан ZPG72 маркийн вакуум шүүлтүүрт шүүгдэж 67.82%-ийн төмрийн агуулгатай баяжмал үйлдвэрлэгдэнэ.

**Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал:** Баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал 4.3 сая тонн бөгөөд үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 85-95%-тай ажиллах үед баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал 814.4 тонн байна.

Схем-2. Баяжуулах үйлдвэрийн хүдэр баяжуулах технологийн схем.



Баянголын төмрийн хүдэр олборлох ил уурхай нь бусад доор дурдсан дагалдах үйлдвэрүүдийг барьж байгуулан ашиглалтанд оруулсан.

- ✓ Бетон зуурмагийн үйлдвэр
- ✓ Нефть бүтээгдэхүүний агуулах түгээх цэг /ШТС/

БТЕГ”ХХК-ийн Баянгол уурхай нь үйлдвэрлэлд түшиглэсэн дараах туслах үйлдвэрүүдийг байгуулан ажиллаж байна.

**Бетон зуурмагийн үйлдвэр:** “Болд төмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийн ордын ашиглалтын үйл ажиллагаа өргөжихийг дагаж шинээр үйлдвэр барих, өргөтгөх, засвар үйлчилгээ, үйлдвэрийн шинэчилэл, ажиллагсадын орон байр барих зэрэг бүтээн байгуулалтын ажилд бетон зуурмагийн хэрэгцээ улам нэмэгдэх юм. Иймээс уурхайг түшиглэсэн бетон зуурмагийн үйлдвэр байгуулсан.

**Нефть бүтээгдэхүүний агуулах түгээх цэг /ШТС/:** “БТЕГ”ХХК-ийн Баянгол уурхай дахь шатахуун түгээх станц нь зөвхөн уурхайн үйл ажиллагаанд зориулагдсан ба уурхайнхүнд машин механизмуудыг дизель түлш болон авто бензинээр тасралтгүй хангах үүрэгтэй ажиллаж байна. Түүний хангалт болон үйлчилгээг Сод монгол, Петровис, Ник зэрэг ХХКуудтай хийсэн хамтарсан гэрээний дагуу ханган ажиллаж байна. Баянгол уурхайн ШТС-ын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар 2012 онд хийж

**“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

гүйцэтгүүлэн түүнд заагдсан заавар зөвлөмжийн дагууд бид байгаль хамгаалах ажлуудыг авч хэрэгжүүлж байна.

“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.

Д/Д	Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Ажлын хэмжээ	Төлөвлөгөө (мян.төг)	Гүйцэтгэл (мян.төг)
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ</b>				
1	Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин тэр дундаа агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийн нэг нь тоосжилт юм. Тоосжилт нь карьер ашиглалт, өрөмдлөг, тэсэлгээ, хөрс, хүдэр тээвэрлэлтээс үүсдэг. Бид тоосжилт бууруулах арга хэмжээг авахдаа тээврийн замд тоосжилт бага үүсгэдэг материал дэвсэх <b>(0,35мм ширхэглэлтэй хаягдал)</b> , усалгаа хийх уламжлалт технологийг давхар ашигладаг. Түүнчлэн тогтоосон хурдны хязгаарыг хэтрүүлэхгүй байх <b>(бүх машины хурд 20-45км/ц)</b> , шинээр зам үүсгэхгүй, батлагдсан маршрутын замаар явуулах зэрэг чиглэлийг мөрдлөг болгон ажиллаж байна.	Уурхайн технологийн зам	50 000.00	ҮАЗ
2	Хөгжил хотхоны ажилчдын амрах байр гал тогоо, оффис зэрэг барилга байгууламжийн дулааныг БНХАУ-д үйлдвэрлэсэн 2.1Мвт-ын хүчин чадалтай халаалтын CDZL2.8-90/АII загварын 2 том зуух, (өвлийн улиралд ашигладаг), 1 жижиг зуух (зуны улиралд ашигладаг) нийт 3-н зууханд утаа шүүгч байршуулаад байна. Тус зуухнууд нь 2-р зэргийн нүүрсийг 100% шатаадаг тул байгаль орчинд ээлтэй сүүлийн үеийн дэвшилтэд технологи юм. Уг халаалтын зуухнуудын янданд Y6-41-5.4C загварын 2Т утаа тоос сорогч, DGC-2-11,12 загварын олон хоолойт тоос утаа сорогч зэрэг шүүлтүүрүүдийг байршуулан ажиллалаа.	Хөгжил хотхон уурын зуух –3ш шүүлтүүр	1 000.0	ҮАЗ
3	Тоос, тоосжилт үүсгэдэг гол хүчин зүйлс нь үйлдвэржилт, замын бүтэц, автомашины хөдөлгөөн, цаг уурын нөхцөл, хөрсний эвдрэл, ногоон байгууламжийн хүрэлцээгүй байдал зэрэг юм. Нарийн мөхлөгт тоосонцор гаргадаг үйлдвэр, уурхай болон хучилтгүй шороон замын тоосны асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байна. Дэлхийн улс орнууд тоос, тоосжилтыг дарах олон аргыг өөр өөрийн онцлог нөхцөл байдал тулгуурлан бууруулах, туршиж, нэвтрүүлэх үйл	Уурхайн технологийн зам	5 000.0	245.0



**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

	ажиллагааг хэрэгжүүлж ажилласаар байна. Хэт хуурай сэрүүн уур амьсгалтай манай оронд агаар дахь тоос, тоосонцорын хэмжээ 2-3 дахин их байдаг. Иймд бид дээрхи улс орнуудын хийсэн судалгааны аргуудаас өөрийн онцлог, нөхцөл байдалд ашиглаж болох аргыг турших ажлыг хийж ажиллалаа.			
<b>Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах</b>				
4	Бид үйл ажиллагаа эхэлсэн цагаасаа олон салаа зам гаргах, хөрс, ургамлын бүрхэвчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж нэгдсэн замын маршрутыг батлан мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, тасралтгүй хяналт тавьж ажиллаж ирсэн. Тайлант онд “Тэрбум мод” хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж ажиллах ажлын хүрээнд мод үржүүлгийн газрыг шинээр байгуулж ажилласан. Тус хэсгийн хөрс нь сул усалгааны танкнуудыг дүүргэх зориулалтаар очих усны машин, бороо ус орсон үед суух, газар ухаж хөрсийг эвдрэлд оруулах, салаа зам гарган ургамлан бүрхэвчийг талхлах зэрэг сөрөг нөлөөллүүдийг үүсгэсэн тул салаа гаргасан замуудыг хааж сайжруулсан зам тавьж, сөрөг нөлөөллийг арилгаж ажиллалаа.	Мод үржүүлгийн зам урт 145м, өргөн 4м	2 000.0	5 397.0
5	Зам арчилгаа, хучилтанд ашиглах боломжтой шороог уурхайн олборлолтын үед тусад нь овоолго үүсгэн ажилласан. 2022 оны маршейдрийн хэмжилтээр 0.24га талбайд 8396м <sup>3</sup> шар шорооны нөөцтэй байна. Тайлант онд зам хучилтанд авто баазын тээврийн машинаар нийт 85 рейс 765м <sup>3</sup> шороог ашигласан байна.	Ашигласан хэмжээ 765м <sup>3</sup> шороо.	ҮАЗ	ҮАЗ
6	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан сав агуулахад хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох ажлын хүрээнд 2022 оны 08 сарын 04 нд асгаралтын журмыг шинэчлэн уурхайн даргаар батлуулж тус журмыг цаашид дагаж мөрдөн ажиллах тал дээр алба хэлтсийн дарга засварын механикуудад танилцуулан, хамтарч ажиллаж байна.	ШТМ бохирдсон хөрсийг саармагжуулах талбай, тосолгооны машин, зориулалтын засварын шоп	5 000.0	3 273.0
<b>Гадаргын болон газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ</b>				
7	Ус хэмнэх маш олон арга, зөвлөмжүүд байна. Үүнээс бид эхний удаад 00-н усны хэрэглээг багасгах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Ажилчдын амьдрах байр,	Өмнөх онтой харьцуулахад ус	ҮАЗ	ҮАЗ

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

	оффис, хоол үйлвэрлэл гэх мэт 14 барилгын 182ш 00-н почкинд 1л савтай усыг 2022.04.07-ны өдөр байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Почкины хэмжээ 8л бөгөөд 1л савтай ус байршуулсан нь 00-н усыг татах болгонд 1л усыг бодитойгоор хэмнэж чадна гэж үзэн, хяналтыг тавьж ажилласан.	ашиглалт 5%-р буурсан		
8	Унд ахуйд ашиглаж буй усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүсийн заагийг тогтоолгож, бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хамгаалалтад авах ажлын хүрээнд хөгжил хотхон, баянгол хотхоны унд ахуйн хэрэглээний худагт ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм мөрдүүлэх мэдээллийн самбар байршуулах ажлыг зохион байгуулж ажиллав.	Хөгжил хотхон, Баянгол хотхон	2 000.0	960.0
9	Уурхайн гүйцэтгэх захирлын 2022-04-21 өдрийн “Нийтийн эзэмшлийн талбайд хийгдэх их цэвэрлэгээг зохион байгуулах удирдамж” төслийн талбайд хийгдэх их цэвэрлэгээний хуваарийн дагуу 2022.05.12-ны өдөр хангайт гол дагуу 63 хүн 250га талбайгаас 980кг хог хаягдал, 2022.08.07-ны өдөр Баянгол дагуу 46 хүн 24га талбайгаас 280кг хог хаягдал, мөн Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022.09.17-ны БТЕГ 22 хүн 4 замын гүүрнээс ерөө тал руугаа 3км зайд голын 2талаар мөн 4 замын автозамын 2 талаар 5км зайд цагаан хаалга 34 хүн 4 замын гүүрнээс дулаан хаан чиглэлд 5км зайд голын арын хэсэгт буюу хийн 490га талбайг хамарсан их цэвэрлэгээ хийж нийт бпортер хог буюу 12тн хог хаягдлыг тус тус түүж, нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.	Хандгайт гол 0,98тн, Баянгол 0,28тн, ерөө гол 12тн. Нийт 13,6тн	2 000.0	22 054.2
<b>Ургамлан нөмрөг, ойн сан, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ</b>				
10	Өмнөх онд нефтийн бүтээгдэхүүн, хүнд металлыг шингээгч хайпераккумулятор ургамлын судалгааг хийж ажилласан. Тус судалгаагаар эгэл бавран, эгэл гаймуу, үлдэн могойн идээ зэрэг ургамал нь монгол оронд ургадаг болох нь тогтоогдсон. Уурхайн бүсэд дээрх 3-н ургамлын 2 нь буюу эгэл бавран, үлдэн могойн идээ ургамал ургадаг болох нь ургамлын хэмжилт судалгаагаар тогтоогдсон. Тайлант онд эгэл бавран оймыг үндсэн ишээр салгаж тарих аргыг туршиж ажилласан. Туршилтын ажил 76%-ийн ургалттай гарсан. Эндээс үзэхэд эгэл бавран найдвартай эрсдэлгүй удмын дамжуулах чадвараа үндэсний системд хадгалагдсан байгаа нь туршилтаас нотлогдлоо. Цаашид уг аргаар ШТМ-аар бохирдсон хөрсөнд тарьж	Үр түүсэн хэмжээ: Эгэл бавран 2,8кг үлдэн могойн идээ 30гр	1 000.0	-

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

	ургуулах ажлыг туршиж ажиллах болно. Мөн тайлант онд эгэл бавран, үлдэн могойн идээ ургамлын үрийг түүж ажилласан. Ирэх төлөвлөгөөт онд түүсэн 2 ургамлын үрийг эрүүл хөрс болон ШТМ-аар бохирдсон хөрсөнд тарьж ургуулах туршилт судалгааны ажлуудыг хийж ажиллахаар төлөвлөж байна.			
11	Үйл ажиллагааны нөлөөгөөр ашиглалтанд өртөж буй модыг зүй зохистой ашиглах талаар сумын БОУБайцаагчийн зөвшөөрлийн дагуу орон нутгийн иргэдийн түлшний хэрэгцээнд 60м3 модыг өгөх ажлыг зохион байгуулж ажилласан.		500.0	ҮАЗ
12	Зүүн ил уурхайн засварын талбай нүүсэнтэй холбоотойгоор уулын засварын баазын барилга объектуудын орчмыг тохижуулах, зүлэгжүүлэх ажлын хүрээнд 240м <sup>2</sup> талбайд согооврын үрээр зүлэгжүүлэх ажлыг хийж ажиллалаа.	240м2 талбайд 5кг согоовор	2 000.0	Өмнөх онд түүсэн үрээр тарилт хийв.
13	2022 онд уурхайн нөлөөллийн бүсэд хамаарах ургамлын мониторингийн 9 цэг, нөхөн сэргээлтийн мониторингийн 4 цэг, нийт 13 цэгээс 50 овгийн 152 зүйл ургамал тус тус бүртгэгдсэнээс 8 зүйл ховор ургамал, 2 зүйл нэн ховор ургамал бүртгэгдсэн байна. Тайлант онд бид дээрхи нэн ховор болон ховор ургамлуудын үрийн генийг санг бэхжүүлэх зорилгоор зарим ургамлын үрийг боловсорч гүйцсэн хугацаанд түүж бэлтгэв. Мөн нөхөн сэргээлт хийгдэх болон хийгдсэн талбайд зүйлийн бүрэлдэхүүнийг нэмэх зорилгоор бусад ургамлын үрүүдийг түүж бэлтгэв.	Нэн ховор 70гр, ховор – 6480гр, элбэг – 13575гр нийт 20125гр	-	-
14	Баянгол уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч буй жигүүртэн шувууд, мэрэгч, ойн амьтдын мониторингийг амьтдын мөр, баас, нүдэн ажиглалт, тодорхой цэгүүдэд камер байршуулах аргаар хийж ажиллалаа. Төслийн зүгээс зэрлэг ан амьтан хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:  ✓ Хууль бус ан агнууртай тэмцэх-Сурталчилгаа, ухуулга хийх. (Ан амьтдыг сүйрлийн ирмэгт хвргэж байгаа нэг том хвчин зүйл бол ангийн гаралтай тvvхий эд, бүтээгдэхvvний зохисгvй буюу хууль бус худалдаа юм). ✓ Амьтны тухай танин мэдэхүйн мэдээ мэдээллийг олон нийтийн сүлжээ (уурхайн нэгдсэн фэйсбүүк грүүп) дамжуулан хүргэж байна. ✓ Амьтан хамгаалах биотехнологийн арга хэмжээг болох хужир мараа тавих, өвөл, хавар идэш тэжээл хомсдсон үед тогтсон цэгүүдэд өвс, хоолны хаягдал болон ногооны хальс зэргийг байршуулан ажилладаг.	500кг ашигт долооц, 100 боодол өвс	3 000.0	500.0

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

	<ul style="list-style-type: none"> <li>✓ Амьтны орон байрыг бий болгох зорилгоор дүйцүүлэн хамгаалах ажлыг ойжуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлдэг.</li> <li>✓ Мэргэжлийн байгууллагуудаар уурхайн бүсэд амьтан, ургамал, шавьжны судалгаа шинжилгээний ажлуудыг 3-5 жилийн давтамжтай хийлгүүлэх зэрэг болно.</li> </ul>			
15	Хууль бус ан агнуурын тухай мэдээлэл сурталчилгаа, экологи эдийн засгийн үнэлгээний талаар, амьтны камерт өртсөн уурхайн бүсэд амьдарч буй амьдтын тухай 2минут 20секундын видео шторк бэлтгэн ажилчдын нэгдсэн грүүп болох “Баянгол уурхай БТЕГ” нэртэй 3600 гаруй хэрэглэгчтэй фасебүүк хуудсанд байршуулан ажиллав.	1 удаа	500.0	-
<b>Нийт</b>			<b>75 000.0</b>	<b>32 429.2</b>

## СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН.

### *Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр:*

1. Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин тэр дундаа агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийн нэг нь тоосжилт юм. Тоосжилт нь карьер ашиглалт, өрөмдлөг, тэсэлгээ, хөрс, хүдэр тээвэрлэлтээс үүсдэг. Бид тоосжилт бууруулах арга хэмжээг авахдаа тээврийн замд тоосжилт бага үүсгэдэг материал дэвсэх (0,35мм ширхэглэлтэй хаягдал), усалгаа хийх уламжлалт технологийг давхар ашигладаг. Түүнчлэн тогтоосон хурдны хязгаарыг хэтрүүлэхгүй байх (бүх машины хурд 20-45км/ц), шинээр зам үүсгэхгүй, батлагдсан маршрутын замаар явуулах зэрэг чиглэлийг мөрдлөг болгон ажиллаж байна.

*Зураг-2.1. Замд тоосжилт бага үүсгэдэг материал (0,35мм ширхэглэлтэй хаягдал) дэвсэж буй байдал.*



Өмнөх жилүүдэд замд нарийн ширхэгтэй элсэрхий-шаварлаг хөрсөөр дэвсэлт хийгддэг байсан. Тус материалын ширхэглэг 0,005мм, шахалтын бат бөхийн хязгаар 44Мпа. Тайлант онд зам арчилгааны инженертэй болсон тул уурхайн технологийн замуудыг тоосжилт бага үүсгэдэг материал ашиглах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Доор замд ашигласан хаягдлын чулуулгын шинж чанарыг үзүүлэв. Үүнд:

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

- Хаягдал чулуулгуудын 90-95% нь олон найрлагат элсэн чулуу бага хэмжээгээр алевро-песчаник, филлит маягийн занраас тогтоно.
- Олон найрлагат элсжин нь кварц –хээрийн жонш-пироксен -амфибол-эпидотот занар, эвэржин, зануужин, филлит занараас бүрдэнэ.
- Хэмхдэс материалаас кварц-5-20%, плагиоклаз -35% хүртэл, КХЖонш -10-25%, гялтгануур -5% хүртэл, ховроор актинолит, лейкоксен, сфен, циркон, турмалин хүдрийн эрдэсүүд тохиолдоно.
- Бутлагдал дахь ширхэглэгийн хэмжээ дундаар 0,35мм хэмжээтэй өнцөглөсөн, ховроор мөлгөржсөн байна.

*Хүснэгт-2.2. Замд дэвссэн материалын чулуулгийн физик механик шинж чанар, хатуулаг.*

Д/д	Дээжийн дугаар	Чулуулгийн төрөл	Эзэлхүүн жин, гр/см <sup>3</sup>	Шахалтын бат бөхийн хязгаар, МПа	Суналтын бат бөхийн хязгаар, МПа	Шилжрэлтийн бат бөхийн хязгаар, МПа	Бат бөхийн коэффициент, Протодьяконов
1	E2102	Элсэн чулуу	3.43	235.27	24.22	55.06	24
2	E2103	Габбро	3.12	159.06	15.99	36.91	16.2
3	E2104	Хувирмал чулуу	3.1	149.06	14.14	33.9	15.2
4	E2105	Элсэн чулуу	2.69	132.36	12.66	30.19	13.5
5	E2106	Элсэн чулуу	2.88	78.43	9.2	19.19	8
6	E2107	Конгломерат	2.71	122.99	13.19	29.19	12.5
7	E2108	Алевролит	2.8	90.56	8.2	20.26	9.2
8	E2111	Элсэн чулуу	2.87	92.21	8.9	21.1	9.4
9	E2112	Габбро	3.34	228.98	22.6	52.8	23.3
10	E2113	Элсэн чулуу	2.9	132.21	11.2	28.88	13.5
11	E2114	Элсэн чулуу	2.93	32.33	2.1	6.4	3.3
12	E2115	Элсэн чулуу	2.74	205.81	19.3	46.61	21
13	E2116	Алевролит	2.66	94.49	8.7	21.26	9.6
14	E2118	Элсэн чулуу	2.74	103	10.23	23.81	10.5
15	E2119	Элсэн чулуу	2.87	86.2	8.4	19.79	8.8
16	E2121	Алевролит	2.83	87.24	7.8	19.43	8.9
17	E2122	Алевролит	2.6	82.89	6.5	17.6	8.4
18	E2123	Элсэн чулуу	2.7	222.25	19.8	49.43	22.7
19	E2125	Элсэн чулуу	2.81	92.63	7.9	20.28	9.4
20	E2126	Алевролит	2.8	133.55	12.3	30.06	13.6
21	E2128	Алевролит	3.39	151.48	13.2	33.42	15.4
22	E2131	Алевролит	2.78	152.72	16.38	36.25	15.6
23	E2132	Алевролит	2.72	119.77	13.1	28.62	12.2
24	E2133	Алевролит	2.54	101.54	10.89	24.1	10.4
25	E2134	Алевролит	2.77	46.8	4.65	10.82	4.8
26	E2135	Конгломерат	2.66	137.18	12.1	30.4	14
<b>Дундаж</b>			<b>2.3</b>	<b>104.6</b>	<b>10.0</b>	<b>23.8</b>	<b>10.7</b>

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

*Зураг-2.2. Тээврийн замд тээвэр хийж буй машины газарт үзүүлэх даралтыг тооцов.*



**Дүгнэлт:** Хүснэгт-2.1-ээс харахад замд дэвссэн хаягдлын шахалтын бат бөхийн хязгаарын дундаж 104.6Мпа байна. Өмнө ашиглаж байсан элсэрхий-шаварлаг хөрсний шахалтын бат бөхийн хязгаарын дундаж 44Мпа байна. Үүнээс харахад замын дэвсэлтэнд хаягдал ашигласнаар тоос үүсэх магадлалыг 2,4дахин багасгаж, чулуулгийн ширхэглэгийн хэмжээг 70 дахин нэмэгдүүлж байгаа нь харагдаж байна.

*Зураг-2.3. Хурдны хязгаар мөрдүүлж буй байдал.*



**Дүгнэлт:** Машин болон бусад шороон замаар явдаг тээврийн хэрэгслүүдийн хурд их байх тусам шороо тоос нэмэгддэг. Судалгаанаас харахад тээврийн хэрэгслийн хурд

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**


нэмэгдэх тусам агаарт дэгдэх PM10 нэмэгддэг байна. Хурдны хязгаарыг 60 км/цагаас 30 км/цаг болгон бууруулснаар тоосны ялгаруулалтыг 65%-аар багасгасан туршлага бий.

*Зураг-2.4.Зам усалгаа хийж буй байдал.*



*Хүснэгт-2.3.Зам усалгааны мэдээ.*

Зам усалгааны эх үүсвэр	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Нийт
Булгийн гол	884	694	1406	1348	912	2494	3642	1420	<b>12800</b>
Хандгайт гол	0	576	810	1272	700	1660	1452	554	<b>7024</b>
БУЦБ	434	2260	1206	1300	1060	2980	1950	800	<b>11990</b>
Шүүрлийн ус	1664	2998	10502	5676	3456	6076	6676	1874	<b>38922</b>
<b>Нийт</b>	<b>2982</b>	<b>6528</b>	<b>13924</b>	<b>9596</b>	<b>6128</b>	<b>13210</b>	<b>13720</b>	<b>4648</b>	<b>70736</b>




- Хөгжил хотхоны ажилчдын амрах байр гал тогоо, оффис зэрэг барилга байгууламжийн дулааныг БНХАУ-д үйлдвэрлэсэн 2.1Мвт-ын хүчин чадалтай



**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

халаалтын CDZL2.8-90/АII загварын 2 том зуух, (өвлийн улиралд ашигладаг), 1 жижиг зуух (зуны улиралд ашигладаг) нийт 3-н зууханд утаа шүүгч байршуулаад байна. Тус зуухнууд нь 2-р зэргийн нүүрсийг 100% шатаадаг тул байгаль орчинд ээлтэй сүүлийн үеийн дэвшилтэд технологи юм. Уг халаалтын зуухнуудын янданд Y6-41-5.4C загварын 2Т утаа тоос сорогч, DGC-2-11,12 загварын олон хоолойт тоос утаа сорогч зэрэг шүүлтүүрүүдийг байршуулан ажиллалаа.

*Зураг-2.5. Уурын зуухны ерөнхий план зураг.*



*Зураг-2.6. Уурын зуухны гаднах зураг.*



Зураг-2.7. Утааны яндангуудад утаа тоос шүүлч байрлуулсан байдал.



Түүхий нүүрс түлэхэд P(2.5), P(10) СО-нүүрсхүчлийн дутуу исэл их хэмжээгээр ялгардаг. Тус зуух нь дээр дурьдсанчлан 2-р зэргийн нүүрсийг 100% бүрэн шатаадаг. Бид түлшиндээ Багануурын уурхайн нүүрсийг ашигладаг. Багануурын нүүрс нь өөрийн фикик, хими шинж чанараараа 2-р зэргийн буюу зөвхөн эрчим хүчний зориулалтаар ашиглагдах төдийгүй дахин боловсруулалт хийгдэн шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш, бусд химийн үйлдвэрлэлийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаа батлагдсан байдаг.

3. Тоос, тоосжилт үүсгэдэг гол хүчин зүйлс нь үйлдвэржилт, замын бүтэц, автомашины хөдөлгөөн, цаг уурын нөхцөл, хөрсний эвдрэл, ногоон байгууламжийн хүрэлцээгүй байдал зэрэг юм. Нарийн мөхлөгт тоосонцор гаргадаг үйлдвэр, уурхай болон хучилтгүй шороон замын тоосны асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байна. Дэлхийн улс орнууд тоос, тоосжилтыг дарах олон аргыг өөр өөрийн онцлог нөхцөл байдал тулгуурлан бууруулах, туршиж, нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласаар байна. Хэт хуурай сэрүүн уур амьсгалтай манай оронд агаар дахь тоос, тоосонцорын хэмжээ 2-3 дахин их байдаг.

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**


Иймд бид дээрхи улс орнуудын хийсэн судалгааны аргуудаас өөрийн онцлог, нөхцөл байдалд ашиглаж болох аргыг турших ажлыг хийж ажиллалаа. Хүснэгт-2.4-т тоосжилтыг бууруулахад өргөн хэрэглэгддэг аргуудыг үзүүлэв.

*Хүснэгт-2.4. Тоосжилтыг бууруулах аргууд.*

Тоосжилтийг бууруулах аргууд	Аргууд	Үнэ	Өр нөлөө
Сэргийлэх	Үйл ажиллагааны явц, практикийг сайжруулах	Өндөр	Өндөр
Арилгах	Тоос цуглуулагч	Дунд зэрэг	Дунд зэрэг
Барьцалдуулах	Химийн бодис, нойтон цацлага, усан хөшиг	Дунд зэрэг	Өндөр
Шингэлэх	Хүчилтөрөгчөөр хангах	Бага	Дунд зэрэг
Тусгаарлах инсулятор	Тусгаарлагч кабин, хүчилтөрөгчийн баг зүүх, тоосжилттой газар ажиллуулахгүй байх хяналт	Дунд зэрэг	Зунд зэрэг

Бид хүснэгт-2.4-т үзүүлсэн аргуудаас химийн бодис ашиглах буюу **Лигносулфонатын органик барьцалдуулагч бодис** ашиглах аргыг сонгож турших ажлыг хийж ажиллалаа.


*Зураг-2.8. Лигносулфонатын органик барьцалдуулагч бодисыг гаргаж авах схем.*






Туршилтаар **Лигносулфонатын 2%-ийн** уусмалыг шингээсэн хөрсний дээж хэр хэмжээний даралтыг тэсвэрлэж, хөрсөнд хэр их чийгшлийг үзүүлж чадаж байгааг тодорхойлох юм. Харьцуулах зорилгоор ус, Лигносулфонат шингээсэн 3 ширхэг хөрсний дээж дээр туршсан болно. UCS тестийг тогтмол 0.5-2.0%/мин-ийн даралтаар шахсан. Тусгайлан бэлдсэн хөрсний дээж хүчний үйлчлэлд хагарч эхлэхэд туршилтыг зогсоосон ба 2 удаагын туршилтын дундаж утгаар нэгдсэн тооцоог гаргасан.

### Судалгааны үр дүн:



“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.



Хүснэгт-2.5. Үр дүн.

Огноо	Зам усалгаанд ашигласан усны хэмжээ м3	Техникийн зардал (сая.төг)	Үр дүн				
			Lin 2% уусмал м3	Усны хэмнэлт м3	Хэмнэсэн усны үнэ сая.төг (580.44 төг)	Техникийн зардал сая.төг (Lig 2%)	Техникийн зардал сая.төг (Lig 2% хэмнэлт)
2019	76,075.00	167.59	41,334.62	34,740.38	20.16	76.53	91.06
2020	104,084.00	209.77	56,553.04	47,530.96	27.59	95.79	113.97
2021	59,899.00	158.77	32,545.55	27,353.45	15.88	72.5	86.26
<b>Нийт</b>	<b>240,058.00</b>	<b>536.13</b>	<b>130,433.21</b>	<b>109,624.79</b>	<b>63.63</b>	<b>244.83</b>	<b>291.3</b>
<b>Хэмнэлт сая.төг</b>							<b>354.93</b>

**Дүгнэлт:** Туршилтаас харахад (График-2.1, график-2.2 харах) зам талбайг усаар услахад хөрс 89Мпа даралт тэсвэрлэж, тоосжилтыг 43%-ийн бууруулж, лигносулфонат 2% уусмалаар усалгаа хийгдсэн хөрс 138Мпа өндөр даралтыг тэсвэрлэж, тоосжилтыг 76% болгон өсгөж байгаа лабораторийн туршилтын үр дүн гарсан.

Хүснэгт-2.7-оос дүнгээс харахад сүүлийн 3-н жилийн хугацаанд 240 058м3 усыг зам усалгаанд ашигласан байна. **Lin2%**-ын уусмалыг зам талбайн усалгаанд ашигласан бол 130 433м3 ус ашиглах ашиглаж 109 624м3 усыг хэмнэх байсан тооцоог харж болох юм. Ус бол нөхөн сэргэгддэггүй, шавхагддаг баялаг. Цаашид бид зам талбайн усалгаандаа **Lin2%**-ын уусмалыг ашиглана гэж тооцвол жилдээ 54% орчим буюу 36541м3 усыг хэмнэх боломжтой тооцоо харагдаж байна. Мөн ус хэмнэхээс гадна техникийн зардлыг мөн 50%

**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

орчимоор хэмнэх тооцоо гарч байна. 2019, 2020, 2021 оны зам усалгаанд ашигласан уснаас харахад манай уурхайд жилд 1.6-2тн Lig 2% уусмал ашиглагдахаар харагдаж байна. 1тн Lig 2% уусмалын зах зээлийн үнэ 163-299доллар (2019-2020он). Жилд 2тн lig 2% уусмал ашиглавал  $2 \times 299 \times 3135 = 1\ 874\ 730$  төг болно.

*Хүснэгт-2.6. Эдийн засгийн тооцоо.*

№	Зардлын төрөл	Зардлын дүн ₮
1	Лабораторийн шинжилгээ	240,000
2	Lin 100% уусмал 1л	5,000
	<b>Нийт зардал</b>	<b>245,000</b>

***Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн чиглэлээр:***

4. Бид үйл ажиллагаа эхэлсэн цагаасаа олон салаа зам гаргах, хөрс, ургамлын бүрхэвчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж нэгдсэн замын маршрутыг батлан мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, тасралтгүй хяналт тавьж ажиллаж ирсэн. Тайлант онд “Тэрбум мод” хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж ажиллах ажлын хүрээнд мод үржүүлгийн газрыг шинээр байгуулж ажилласан. Тус хэсгийн хөрс нь сул усалгааны танкнуудыг дүүргэх зориулалтаар очих усны машин, бороо ус орсон үед суух, газар ухаж хөрсийг эвдрэлд оруулах, салаа зам гарган ургамлан бүрхэвчийг талхлах зэрэг сөрөг нөлөөллүүдийг үүсгэсэн тул салаа гаргасан замуудыг хааж сайжруулсан зам тавьж, сөрөг нөлөөллийг арилгаж ажиллалаа.

*Зураг-2.9. Олон салаа замыг хааж, тавьсан байдал.*



**“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

*Хүснэгт-2.7. Эдийн засгийн тооцоо:*

№	Зардлын төрөл	Дүн (төг)
1	Ажилласан техникийн зардал	2,195,657
2	Шатахууны зардал	2,037,096
3	Цалингийн зардал	637,724
	<b>Нийт зардал</b>	<b>5,396,922</b>

5. Зам арчилгаа, хучилтанд ашиглах боломжтой шороог уурхайн олборлолтын үед тусад нь овоолго үүсгэн ажилласан. 2022 оны маршейдрийн хэмжилтээр 0.24га талбайд 8396м<sup>3</sup> шар шорооны нөөцтэй байна. Тайлант онд зам хучилтанд авто баазын тээврийн машинаар нийт 85 рейс 765м<sup>3</sup> шороог ашигласан байна.

*Зураг 10. “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ний Баянгол уурхайн Баруун ил уурхайн 4-р овоолгын доор байрлах шар хөрсний овоолог.*



*Хүснэгт-2.8. Замын хучилтанд ашигласан хөрсний бүртгэл.*

Нөөцөлсөн 4-р овоолгоос бааз авсан байдал								
№	Машины	Хаанаас	Хаашаа	Зориулалт	Ажилласан цаг	Рейсийн тоо	Туулсан зам /км/	Огноо
1	Норд 31-55. Норд	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	9	25	235	5/6/2022
2	STR 31-57СЭА STR	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	8.5	24	264	5/6/2022
3	Норд 31-55. Норд	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	1.08	3	28.2	5/5/2022
4	STR 31-57СЭА STR	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	1	2	18.8	5/5/2022
5	Норд 31-55. Норд	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	1	2	18.8	5/4/2022
6	Норд 31-55. Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/4/2022
7	Норд 04-73. Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
8	STR 57-14 STR	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	0.15	1	5.6	5/3/2022
9	Норд 31-55. Норд	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	3.6	9	100.8	5/3/2022
10	STR 57-13 STR	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
11	Норд 21-06. Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
12	STR 31-57СЭА STR	4-р овоолгоос	9-р үйлдвэрийн зам	Хөрс	4	10	112	5/3/2022
13	Styer 11-05 Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
14	54-59 ДГС 54-59 ДГС Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
15	Styer 33-52 ДГС Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
16	Styer 51-54 ДГС Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/3/2022
17	Норд 58-67 ДГА Норд	4-р овоолгоос	27-н тойрог	Хөрс	0.2	1	8.2	5/2/2022
					<b>30.13</b>	<b>85</b>	<b>857</b>	

**“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.**

6. ШТМ-ыг стандартын шаардлага хангасан сав агуулахад хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох ажлын хүрээнд 2022 оны 08 сарын 04 нд асгаралтын журмыг шинэчлэн уурхайн даргаар батлуулж тус журмыг цаашид дагаж мөрдөн ажиллах тал дээр алба хэлтсийн дарга засварын механикуудад танилцуулан, хамтарч ажиллаж байна. Уг журмын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

*Зураг-2.11. Хаягдал чулуулгийг замын дэвсгэлтэнд ашиглаж буй байдал.*



ШТМ-ыг стандартын шаардлага хангасан сав агуулахад хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох ажлын хүрээнд асгаралтын журмыг шинэчлэн, уурхайн гүйцэтгэх захиралаар батлуулж, тус журмыг цаашид дагаж мөрдүүлэх талаар дотоод





“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

Зураг-2.13. Засвар үйлчилгээний цэг (Шоп)



Тус уурхай нь хаягдал тос маслог хадгалах нийт 150 тн тос маслог цуглуулах хүчин чадал бүхий хаягдлын 5 танктай ба тэдгээрийг дүүрэх их хэмжээгээр төвлөрөхөөс урьдчилан сэргийлэн дотоодын хоёрдогч түүхий эд дахин боловсруулагч, ашиглагч “Сэлэнгэ АЗЗА” ХХК, “Алтан Оршихуй” ХХК компаниудад тогтмол нийлүүлж хамтран ажиллаж байна. Тайлант онд “Алтан Оршихуй” ХХК 154тн, “Сэлэнгэ АЗЗА” ХХК 88тн ажилласан тос масло нийлүүлж ажилласан байна. (Гэрээ, дагалдах хуудсыг хавсаргав.)

Зураг-2.14. Хоёрдогч түүхий эд дахин боловсруулагч компанид ажилласан тос, масло нийлүүлж байна.



Гинжит болон карьерт удаан хугацаагаар ажиллаж буй техникүүдэд МЦҮ болон шаардлагатай нэмэлт тосолгоог хийж ажиллах, автомат базууртай зориулалтын тослогоо үйлчилгээний машинаар хөрсөнд асгаралт үүсгэхгүйгээр батлагдсан хуваарийн дагуу тосолгоо үйлчилгээг хийж байна.

“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

*Зураг-2.15. Тос тосолгооны үйлчилгээний машин карьерт ажиллаж буй техник болон гинжит техникуудад үйлчилгээ хийж буй байдал.*



Түр болон удаан хугацаагаар зогссон техникийн доор дусал хэлбэрээр үүсэх асгарал мөн шланк задрах оринг сэтрэх гэх мэт уридчилан тааварлашгүй гэнэтийн асгаралт үүссэн тохиолдолд бохирдсон хөрсийг нар, салхиар саармагжуулах зориулалтын саармагжуулах 24м2 талбайг байгуулан ажиллаж байна. Цаашид нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрсөнд нефтийн гаралтай бүтээгдэхүүнийг өөртөө шингээж саармагжуулах чадвар бүхий хайперакумлятор ургамлуудыг тарих туршилт судалгааны ажлыг хийж ажиллахаах бэлтгэл ажлуудыг эхлүүлээд байна.

“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

Зураг-2.16. ШТМ-аар бохирдсон хөрс саармагжуулах талбайд нефтийн бүтээгдэхүүнээр блхирдсон хөрс хадгалж буй байдал.



Хүснэгт-2.9. Тос маслоны асгаралтаар бохирдсон хөрс хадгалж саармагжуулах талбайн өртгийн тооцоо


№	ТЭМ-ын нэр	Хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Цемент	15	ш	13,050	195,750
2	Тоосго /тал	5000	ш	250	1,250,000
3	Элс	2	тн	18,000	31,680
4	Ус	1	тн	10,000	10,000
6	Бусад зардал				124,633
	<b>Нийт</b>				<b>1,612,063</b>
Техникийн зардал					
№	Зардлын төрөл	Хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Түлш	67	литр	4,030	270,010
2	ҮХЭХШ (76-08)				4,637
3	ҮХЭХШ (43-29)				39,258
4	ҮХЭХШ (31-56)				7,290
	<b>Нийт</b>				<b>321,195</b>
Ажилчдын цалингийн зардал					
№	Албан тушаал	Ажилчны тоо	Цалин ₮	ЭМ, НДШ ₮	Нийт цалин ₮
1	Байгал орчны инженер	1	562,650	75,958	638,608
2	Үйлчилгээний машин жолооч	1	224,700	30,335	208,678
3	Туслах ажилтан	3	1,075,325	145,169	492,234
	<b>Нийт</b>	5			<b>1,339,519</b>
	Тайлбар. Байгал орчны инженер, туслах ажилтан нарыг нийт 3 өдөр, өдрийн 10 цаг				

ажилласан, үйлчилгээний машины жолооч нарыг нийт 13 цаг ажилласнаар цалингийн зардлыг тооцов. Нийт зардал (төгрөг) – 3,272,777

*Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр:*

7. Дэлхийн хүн амын өсөлт болон улс орнуудын хотжилт, хөдөө аж ахуйн үсрэнгүй хөгжлийг даган цэвэр усны хэрэглээ мэдэгдэхүйцээр өсөж байгаа. Энэ өссөж буй хэрэгцээг хангахаар хаа сайгүй усан хангамжийн системүүд бий болж байгаа хэдий ч өнөөдөр дэлхийн хүн амын 40% нь усны хомсдолтой нөхцөлд амьдарч байгаа бөгөөд цаашлаад 2025 он гэхэд 2/3 нь ийм байдалд орно гэсэн тооцоо байдаг. Нэгэн тоо баримт дурдахад өнгөрөгч онд улсын хэмжээнд гол мөрөн, булаг шандыг тооллогод хамруулахад 6700 гол, 3600 нуур, 10 мянга шахам булаг хамрагдсан байна. Үүнээс 586 гол ширгэж, 480 булаг, 1522 булаг хатаж үгүй болсон харамсалтай тоо баримт гарчээ. Эдгээр ширгэж, хатсан гол, нууруудын 60-70 хувь нь дахиж хэзээ ч сэргэхгүй гэсэн тооцоо гарч байна. Иймд бид цаашид ус хэмнэх, усны хэрэглээг хянах шаардлага зайлшгүй гарч байна. Ус хэмнэх маш олон арга, зөвлөмжүүд байна. Үүнээс бид эхний удаад 00-н усны хэрэглээг багасгах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Ажилчдын амьдрах байр, оффис, хоол үйлвэрлэл гэх мэт 14 барилгын 182ш 00-н почкинд 1л савтай усыг 2022.04.07-ны өдөр байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Почкины хэмжээ 8л бөгөөд 1л савтай ус байршуулсан нь 00-н усыг татах болгонд 1л усыг бодитойгоор хэмнэж чадна гэж үзэн, хяналтыг тавьж ажилласан.


*Зураг-2.17. Почкинд устай сав байрлуулж буй байдал.*



“Болдгөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

Хүснэгт-2.10. 2021, 2022 оны усны хэрэглээг тоолуурын заалтаар жилээр харьцуулалтыг хийв.

Тоолуурын заалтаар	4 сар (м3)	5 сар (м3)	6 сар (м3)	7 сар (м3)	8 сар (м3)	9 сар (м3)	Нийт (м3)	Ажиллах хүч	Нэг хүнд ноогдох усны хэмжээ /л/хон
2021 он	2519	7949	5945	4697	5594	4262	30966	1207	25.66
2022 он	3003	5480	4947	4620	6056	5311	29417	1604	18.34



**Дүгнэлт:** 2021, 2022 оны (4-9 сар) усны тоолуурын заалтаар усны хэрэглээг харьцуулав. 2021 онд төслийн хэмжээнд 3-н ээлжээр 1207 хүн, 2022 онд 4-н ээлжээр 1604 хүн ажилласан байна. 2022 оны усны хэрэглээг өмнөх оны усны хэрэглээтэй харьцуулахад ( Нийт усны хэрэглээг ажилласан хүний тоонд харьцуулав) 5%-ийн усны хэмнэлт хийж ажилласан байна. 2021 онд 1 хүнд ноогдох усны хэрэглээ 25.66л/хон байсан бол 2022 онд 18.34л/хон болж буурсан буюу хоногт 7.32л/хон усыг нэг хүн хэмнэж ажилласан байна гэж дүгнэж байна.

- Унд ахуйд ашиглаж буй усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүсийн заагийг тогтоолгож, бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хамгаалалтад авах ажлын хүрээнд хөгжил хотхон, баянгол хотхоны унд ахуйн хэрэглээний худагт ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм мөрдүүлэх мэдээллийн самбар байршуулах ажлыг зохион байгуулж ажиллав.

“Болдтөмөр Ерөө гол” (БТЕГ) ХХК-ийн Баянгол уурхайн төмрийн хүдрийг ил аргаар олборлох төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

Зураг-2.18. Ундны ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах мэдээллийн самбар.




Хүснэгт-2.11. Эдийн засгийн тооцоо.

№	Зардлын төрөл	Зардлын дүн ₮
1	Хэвлэл 100x50	42,000
2	Самбар материал 100x50см, хөл 2.1м-2 хөл	54,000
	<b>Нийт зардал</b>	<b>96,000</b>

